



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, 2 нэрийн нийт 30,800,000.00 (гучин сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтувшин болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захирагааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (холбогдох зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) түүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

132001518

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарын  
2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БУРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАЛГААЛТ

Д/Д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашигпалтад орсон он	Нийт гүйлт, км /мянга/	Балансын үнэ, хүримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	<b>Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв</b> УАЗ-пургон, 76-39 БУА, Арап № 80450365	2007/2008	741082	14,600,000.00	800,000.00
2.	<b>Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв</b> УАЗ 22069-033, 18-46 УВА, арап №80462394	2008/2008	836381	16,200,000.00	700,000.00
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>30,800,000.00 (гучин сая найман зуун мянган төгрөг)</b>	<b>1,500,000.00 (нэг сая таван зуун мянган төгрөг)</b>